



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРООНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 06 сарын 22 өдөр

Дугаар 336

Улаанбаатар хот

“Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг
зохион байгуулах ажлын удирдамжийг батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.5, Монгол Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 3.1.6, 3.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлын удирдамжийг хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан удирдамжид заасан чиг үүргийн дагуу Кодексийн хэрэгжилтийг зохион байгуулах, түүнд хяналт тавьж ажиллахыг Компанийн засаглал, комплайнсын хэлтэс /А.Авир/-т үүрэг болгосугай.
3. Энэхүү удирдамжийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

151830000739

Санхүүгийн зохицуулах хорооны даргын
2022 оны 06 сарын 22 ний өдрийн
336 тушаалын хавсралт



САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО



**“КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН
ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
АЖЛЫН УДИРДАМЖ**

2022 он

УДИРТГАЛ

Хөгжингүй орнуудын сайн туршлагад тулгуурлан Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-аас компанийн засаглалын суурь зарчмуудыг 1999 онд анх баталж, 2004 онд нэмэлт, өөрчлөлт оруулан улмаар 2015 онд шинэчилсэн бол Олон улсын компанийн засаглалын холбоо (ICGN)-ны 2001 онд анх баталсан “Дэлхийн засаглалын зарчмууд” 2017 онд шинэчлэгдэж, 2021 онд засвар оров. Түүнчлэн байгаль орчин, нийгэм, засаглалын чиг хандлагатай уялдуулан сүүлийн жилүүдэд улс орнууд компанийн засаглалын кодексоо шинэчлэх үйл явц өрнөсөн.

Манай орны хувьд Улсын Их Хурлаас 2006 онд баталсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ээр тус Хороонд олгосон компанийн засаглалын зарчмыг нэвтрүүлэх, боловсронгуй болгох бүрэн эрхийн хүрээнд 2007 онд анх удаа “Компанийн засаглалын кодекс” батлагдан нэвтрүүлж эхэлсэн бол 2014 онд шинэчилсэн байдаг.

Эдүгээ 2014 оны “Компанийн засаглалын кодекс”-ийг олон улсад гарч байгаа засаглалын шинэчлэлийн чиг хандлагад нийцүүлэх, нөгөө талаас түүний хэрэгжилт нь хангалтгүй байгаа зэргийг харгалзан дахин шинэчлэх хэрэгцээ шаардлага үүссэн. Тухайлбал, Европын сэргээн босголтын банкны 2017 оны “Шилжилтийн эдийн засаг дахь компанийн засаглал: Монгол Улс” тайланд манай орны засаглалын кодексийн агуулга нь хэт ерөнхий, зарим чухал асуудлыг орхигдуулсан, кодексийн хэрэгжилтэд хяналт тавих бүтэцгүйгээс хэрэгжилт хангалтгүй, компаниуд засаглалын талаар нийтэд тайлагнадаггүй гэж дүгнэсэн байна.

Иймд Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 145 дугаар тогтоолоор “Компанийн засаглалын кодекс”-ийг гуравдахь удаагаа шинэчилж батлав. Энэхүү кодексийг боловсруулах явцад 2018-2021 онуудад шинэчлэгдсэн нийт 12 орны компанийн засаглалын кодексийг судалсан болно.

Өмнөх кодексийн хэрэгжилтэд гарч байсан алдаа, дутагдлаас сургамж авч энэхүү шинэчилсэн кодексийг олон улсад түгээмэл “*Хэрэгжүүл, эсвэл Тайлбарла*” гэсэн тайлагналын зарчимд суурилан кодексийн хэрэгжилтийг хангуулах буюу шинэ кодексоор өгөгдсөн үүргийн хэрэгжилтийг тухайн компани тайлагнахдаа уг кодексийн хавсралтад буй маягтын дагуу асуулга тус бүрийг хэрхэн биелүүлсэн, биелүүлээгүй бол шалтгаан, эсхүл түүнийг орлох бүтэц, зохион байгуулалтын өөр арга хэмжээ авсан, хэрэв биелүүлэхээр зорьж байгаа бол хэрэгжүүлэх хугацаа зэргийг Хороо болон арилжаа эрхлэх байгууллагаас шаардсан хугацаанд тайлагнахаас гадна компанийн жилийн үйл ажиллагааны тайланд тусган, цахим хуудсандаа байршуулах шаардлагатай. Мөн компанийн төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) нь “Компанийн засаглалын кодекс”-т нийцүүлэн баталж, дотооддоо мөрдөх бодлогын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг боловсруулахад жишиг болох үүднээс энэхүү кодексийн хавсралтаар “Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлэх хөтөлбөрийн үлгэрчилсэн загвар”-ыг оруулсан. Эдгээрийг ТУЗ-өөс өөрийн компанийн онцлогт нийцүүлэн баталж, хэрэгжилтэд нь хяналт тавихад ашиглах боломжтой.

Нээлттэй хувьцаат компани, даатгагч, итгэлцлийн үйлчилгээ эрхлэгч банк бус санхүүгийн байгууллага, хөрөнгө оруулалтын менежментийн компаниуд “Компанийн засаглалын кодекс”-ийг амжилттай хэрэгжүүлснээр OECD-ын “Компанийн засаглалын тулгуур зарчмууд”, ICGN-ны “Дэлхийн засаглалын зарчмууд” болон хөгжингүй орнуудад мөрдөгдөж буй компанийн засаглалын сайн жишиг, зарчмуудыг үйл ажиллагааны онцлог, бизнесийнхээ хөгжлийн үе шатанд нийцүүлэх боломжтой.

АЖЛЫН УДИРДАМЖ

“Компанийн засаглалын кодекс”-ийг амжилттай хэрэгжүүлснээр компанийн засаглалын тогтолцооны гол субъект болох ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа илүү тодорхой болох, ТУЗ, гүйцэтгэх удирдлагын эрх хэмжээ, үүрэг, хариуцлага нарийвчлан зааглагдснаар хувьцаа эзэмшигч, бусад оролцогч талуудын эрх ашиг хохирох явдал багасахад шууд эерэг нөлөө үзүүлэх үр дүнтэй.

Ингэснээр компаниудын хуримтлуулсан туршлага хомс, оролцогч талуудын чадавх харилцан адилгүй, эрх зүйн гаднах орчин болон компанийн өөрийн дотоод зохицуулалт хангалтгүй зэрэг сул талууд арилах нөхцөл бүрдэнэ.

Эцсийн дүндээ тухайн компанийн засаглалын тогтолцоо хэдий чинээ үр дүнтэй байх нь ёс зүйтэй бизнесийн урт хугацааны тогтвортой хөгжлийг хангах бөгөөд цаашлаад улсын санхүүгийн тогтвортой байдалд эерэг нөлөө үзүүлнэ.

Иймд манай орны компанийн засаглалын дэд бүтцийн байгууллагууд болох Санхүүгийн зохицуулах хороо, нээлттэй компаниуд болон тусгай зөвшөөрөл эзэмшигчид, мэргэжлийн холбоод, сургалтын байгууллагуудын уг кодексийг хэрэгжүүлэхэд оролцох эрх хэмжээ, чиг үүргийг тусгайлан зааж, нэгдсэн зохион байгуулалтад оруулснаар бүх талуудын оролцоог оновчтой тодорхойлон урт болон дунд хугацаанд хэрэгжүүлэх шаардлага үүсээд байна.

Үүний дагуу Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлын удирдамжийг боловсруулсан бөгөөд үүсч болох нөхцөл байдалд нийцүүлэн шинэчилнэ.

Энэхүү ажлын удирдамж нь компанийн засаглалын зарчмыг нэвтрүүлэх, боловсронгуй болгоход оролцогч талуудын баримтлах зарчим, чиг үүрэг, зохион байгуулалт, хүрэх замыг тодорхойлж, нэгдсэн ойлголтыг бий болгоход дэмжлэг үзүүлэх ач холбогдолтой.

АГУУЛГА

1. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ДЭД БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- 1.1 Санхүүгийн зохицуулах хорооны бүрэн эрх 5
- 1.2 Дэд бүтцийн байгууллагуудын чиг үүрэг 5

2. КОДЕКСИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРЧИМ

- 2.1 Тайлагнал 6
- 2.2 Эрсдэлийн үнэлгээ 6

3. СУРГАЛТ

- 3.1 Компанийн засаглалын сургалт, гэрчилгээ олголт 8
- 3.2 Захиалгат болон бусад сургалт, мэдээлэл 8

4. КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ХЯНАЛТ

- 4.1 Нэмэлт тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, бүртгэх 8
- 4.2 Зайны хяналт..... 9
- 4.3 Газар дээрх хяналт..... 9
- 4.4 Зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээ..... 9
- 4.5 Гүйцэтгэлийн хяналт..... 9
- 4.6 Тайлагнал, үнэлгээ 10

НЭГ. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ДЭД БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

1.1. Хорооны бүрэн эрх

Монгол Улсын Их Хурлаас 2006 онд баталсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ээр тус Хороонд зохицуулалтын салбарт олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн компанийн засаглалын зарчмыг нэвтрүүлэх, боловсронгуй болгох үндсэн зорилгыг ханган ажиллах бүрэн эрхийг олгосон.

“Компанийн засаглалын кодекс”-оор хүлээсэн үүргийн дагуу нээлттэй хувьцаат компани, даатгагч, итгэлцлийн үйлчилгээ эрхлэгч ББСБ, ХОМК-д компанийн засаглалын зарчмыг нэвтрүүлэх, түүнд тавих хяналтыг Компанийн засаглал, компайнсын хэлтэс хэрэгжүүлнэ.

Компанийн засаглал, компайнсын хэлтэс нь зохицуулалтын салбарт компанийн засаглал, комплайнсыг нэвтрүүлэх чиглэлээр дараахь чиг үүрэгтэй:

- зохицуулалтын орчинг боловсронгуй болгох, хэрэгжилтэд нь хяналт тавих;
- кодексийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх;
- олон улсын жишиг, зарчмыг нутагшуулах, мөрдүүлэх;
- судалгаа, шинжилгээ хийх;
- “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг үнэлэх аргачлалыг боловсруулах, үнэлэх, дүгнэлт гаргах;
- зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх, гарсан зөрчлийг арилгуулах.

Хорооны Санхүүгийн боловсрол, сургалтын алба нь дангаар болон мэргэжлийн холбоо, ТББ болон сургалтын байгууллагатай хамтран компанийн засаглалын гэрчилгээ олгох болон ахисан шатны сургалтууд, комплайнсын болон тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулах эрх олгох, мэргэшүүлэх, захиалгат сургалт, семинар, хэлэлцүүлгийг зохион байгуулна.

1.2. Дэд бүтцийн байгууллагуудын чиг үүрэг

Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага:

Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага (Бирж) нь компанийн засаглалын чиглэлээр дараахь чиг үүрэгтэй:

- “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг хангах, хангуулах, Хорооноос боловсруулсан аргачлалын дагуу үнэлэх, олон нийтэд мэдээлэх, холбогдох сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулах;
- зохицуулалтын орчинг боловсронгуй болгох чиглэлээр санал өгөх;
- өөрийн болон бүртгэлтэй үнэт цаас гаргагчийн мэдээлэл, тайлагналын үнэн зөв, ил тод байдлыг хангах, хангуулах зохицуулалтыг хэрэгжүүлэх;
- олон улсын жишигт нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэх.

Мэргэжлийн холбоо:

Мэргэжлийн холбоо (Холбоо) нь Хороотой хамтран холбогдох сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулахаас гадна компанийн засаглалыг сайжруулах чиглэлээр дараахь үйл ажиллагааг явуулна:

- “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг Хорооноос боловсруулсан аргачлалын дагуу үнэлэх, олон нийтэд мэдээлэх;
- зохицуулалтын орчинг боловсронгуй болгох чиглэлээр санал өгөх;

- олон улсын жишиг, сайн жишээг нутагшуулах, мэргэжлийн ёс зүйн стандартыг тодорхойлох, нэвтрүүлэх;

- гишүүдийнхээ эрх ашгийг хамгаалах, тэдгээрийн хүний нөөцийг чадваржуулах, судалгаа, мэдээллийн дэмжлэг үзүүлэх.

Төрийн бус болон сургалтын байгууллага:

ТББ нь Хороотой хамтран холбогдох сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулахаас гадна бизнесийн ёс зүй, удирдан зохион байгуулах арга барил бүхий үндэсний компани, бизнес эрхлэгчдийг дэмжих чиглэлээр дараахь үйл ажиллагааг явуулна:

- зохицуулалтын орчинг боловсронгуй болгох чиглэлээр санал өгөх;
- гишүүнчлэл болон түншлэл дээр үндэслэн судалгаа хийх, зөвлөгөө үзүүлэх;
- компанийн засаглалын хөндлөнгийн үнэлгээ хийх, олон нийтэд мэдээлэх.

ХОЁР. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРЧИМ

2.1. Тайлагнал

“Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг олон улсад түгээмэл тогтсон “Хэрэгжүүл, эсвэл тайлбарла” гэсэн тайлагналын зарчмаар хангуулна.

Нээлттэй хувьцаат компани, даатгагч, банк бус санхүүгийн итгэлцлийн үйлчилгээ болон хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхэлдэг компани кодексийн хэрэгжилтийг тайлагнахдаа түүнд дурдсан нийт 36 зүйлийг хэрхэн биелүүлсэн, хэрэв биелүүлээгүй бол яагаад буюу орлох бүтэц, зохион байгуулалтын ямар арга хэмжээ авсан, биелүүлэх зорилт тавьж байгаа бол хугацааг зааж, кодексийн хавсралт болох асуулга бүхий тайлангийн маягтын дагуу нарийвчлан тайлбарлах үүрэгтэй.

Тухайлбал, нээлттэй хувьцаат компанийн хувьд кодекс заасан засаглалын зарчмуудын хэрэгжилтийг үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлэх ба кодексийн хэрэгжилтийн үнэлгээнээс хамаарч тухайн компанийн үнэт цаасны бүртгэлийн ангилал өөрчлөгдөх нөхцөл бүрдэх бол нөгөө талдаа, хөрөнгө оруулагч засаглал талаас нь үнэлж, шийдвэрээ гаргах чанарын үзүүлэлт бий болно.

Харин даатгагч, банк бус санхүүгийн итгэлцлийн үйлчилгээ болон хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхэлдэг компани нь Хорооноос шаардсан хугацаанд хэрэгжилтээ тайлагнана.

Дээрхээс гадна кодексийг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн этгээд нь компанийн жилийн үйл ажиллагааны тайланд тусган, компанийн цахим хуудсанд байршуулах шаардлагатай.

2.2. Эрсдэлийн үнэлгээ

Үнэлгээний зорилго:

“Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг Хорооноос боловсруулсан аргачлалын дагуу үнэлэх, компанийн засаглалын тогтолцоонд тулгарч буй асуудлыг тодорхойлох, түүнд үндэслэн заавар, зөвлөмжийг боловсруулан мөрдүүлэх замаар тухайн компанийн засаглалын түвшинг сайжруулахад үнэлгээний зорилго нь оршино.

“Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн зайны үнэлгээг компанийн төлөөлөн удирдах зөвлөл (ГУЗ)-өөс томилогдсон холбогдох эрх бүхий албан тушаалтан уг кодексийн хавсралт болох асуулгын маягтын дагуу гүйцэтгэж, оноогоор үнэлнэ. Компанийн ирүүлсэн

зайны үнэлгээг баримтад үндэслэн үнэлгээний хяналтын оноо болон хувиар нэгдсэн дүнг тооцно.

Тухайн компанийн үнэлгээний нэгдсэн дүнг тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлтэй холбоотой шийдвэр гаргах, салбарын компанийн засаглалын тухайн үеийн нөхцөл байдлыг тодорхойлох болон эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр дүн шинжилгээ хийх, мөн компанийн засаглалын түвшингийн нэгдсэн судалгаа гаргаж олон нийтэд мэдээлэл өгөх зорилгоор ашиглана.

Үнэлгээний дүнг үндэслэн компанид тухайлсан зөвлөмж, үүрэг, даалгаврыг хүргүүлэх ба тэдгээрийн биелэлтээр зайны үнэлгээний ахиц дэвшлийг тодорхойлно.

Үнэлгээгээр эрсдэлтэй гэж дүгнэгдсэн, эсхүл үнэлгээг Хороо болон бирж, мэргэжлийн холбооноос тухай бүр шаардсан хугацаанд ирүүлээгүй тохиолдолд “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг хангалтгүй гэж тооцно.

Үнэлгээний бүтэц: “Компанийн засаглалын кодекс”-ийн үнэлгээний загвар нь нийт 36 асуулга бүхий дараах бүтэцтэй тайлан байна. Үүнд:

№	Гарчиг	Авбал зохих нийт оноо	Үнэлсэн оноо	Хяналтын оноо	Үнэлгээний хувь
1	ГУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12			
2	ГУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10			
3	Тайлагнал, мэдээллийн ил тод байдал	6			
4	Аудит, хяналтын тогтолцоо	6			
5	Эрсдэлийн удирдлага	8			
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6			
7	Оролцогч талуудын эрх ашиг	8			
8	Компанийн соёл	6			
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10			
	Нэгдсэн дүн	72			

Үнэлгээний аргачлал:

Асуулга тус бүрийн хувьд бүрэн хэрэгжүүлсэн, эсхүл үндэслэл бүхий тайлбар гаргасан бол 2, хэсэгчлэн хэрэгжүүлсэн, эсхүл хугацаа бүхий хэрэгжүүлэх арга хэмжээ, зорилгоо тайлбарласан бол 1, үнэлгээ ирүүлээгүй бол 0 гэсэн оноогоор тус тус үнэлэх ба хэрэгжилт болон тайлбарыг тус бүрээр оруулна.

Үнэлгээний нэгдсэн дүнд үндэслэн тухайн байгууллагын “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг дараах байдлаар үнэлнэ:

- авбал зохих нийт онооны 90 хувь болон түүнээс дээш - засаглал сайн, эрсдэлгүй;
- 70-89 хувь – засаглал дунд, эрсдэл үүсч болзошгүй тул зөвлөмж хүргүүлэх;
- 50-69 хувь – засаглал хангалтгүй, эрсдэлтэй тул зайны болон газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн;
- 49 болон түүнээс доош хувь – засаглал муу, өндөр эрсдэлтэй тул зохицуулалтын арга хэмжээ авах шаардлагатай.

ГУРАВ. СУРГАЛТ

3.1. Компанийн засаглалын сургалт, гэрчилгээ олголт

Хорооны даргын 2021 оны 91 дүгээр тушаалаар баталсан “Санхүүгийн зохицуулах хорооны сургалтын журам”-ын дагуу Хороотой сургалт зохион байгуулах гэрээ байгуулсан мэргэжлийн холбоо, ТББ, сургалтын байгууллага нь Хороотой хамтарч компанийн засаглалын сургалтыг явуулна.

Сургалтыг ТУЗ-ийн гишүүд болон ТУЗ-ийн нарийн бичгийн даргад компанийн засаглалын гэрчилгээ олгохоор тус тусад нь төрөлжүүлэн зохион байгуулах ба тус бүрийн гэрчилгээний хүчинтэй хугацаа гурван жил байна.

3.2. Захиалгат болон бусад сургалт, мэдээлэл

Тусгай зөвшөөрөлтэй этгээд нь холбогдох хууль тогтоомж, Хорооноос гаргасан захиргааны хэм хэмжээний актыг дагаж мөрдөх үүргийг хүлээдэг ба зохицуулагчийнн зүгээс тасралтгүй үргэлжлэх зайны болон газар дээрх хяналт шалгалт хийхтэй зэрэгцэн эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор сургалт, мэдээллээр дамжуулан зохицуулалттай этгээдэд туслалцаа үзүүлэх нь ач холбогдолтой.

Сургалт, мэдээлэл, үүсч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхдээ танхим болон цахим хэлбэрээр зохион байгуулах, хүргүүлэх олон талын сувгийг ашиглана.

ДӨРӨВ. КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ХЯНАЛТ

4.1. Нэмэлт тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, бүртгэх

Хорооны бүртгэлийн нэгж нь үнэт цаас гаргагч болон тусгай зөвшөөрөл бүхий даатгагч, итгэлцлийн үйлчилгээ үзүүлэгч банк бус санхүүгийн байгууллага, хөрөнгө оруулалтын менежментийн компаниас дараах тохиолдолд “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн тайланг хүсэлт гаргагчаас гаргуулан Компанийн засаглал, комплайнсын хэлтэст хүргүүлнэ:

Үнэт цаас гаргагч:

- энгийн хувьцаанд суурилсан опцион болон хөрвөх нөхцөлтэй өрийн хэрэгслийг бүртгүүлэх;
- компанийг нэгтгэх;
- хувьцааг хуваах, эсхүл нэгтгэх, өрийг хувьцаагаар солих;
- бусад.

Даатгалын компани:

- тусгай зөвшөөрөл нэмж авах;
- дүрмийн сангийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах;
- энгийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг бусдад барьцаалах;
- бусад.

Итгэлцлийн үйлчилгээ үзүүлэгч банк бус санхүүгийн байгууллага:

- тусгай зөвшөөрөл нэмж авах;
- хаалттай өрийн бичиг бүртгүүлэх;
- бусад.

Хөрөнгө оруулалтын менежментийн компани:

- хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах;
- бусад.

Компанийн засаглал, компайнсын хэлтэс нь үнэт цаас гаргагч болон тусгай зөвшөөрөл бүхий даатгагч, итгэлцлийн үйлчилгээ үзүүлэгч банк бус санхүүгийн байгууллага, хөрөнгө оруулалтын менежментийн компаниас ирүүлсэн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн тайланг нотлох баримтад тулгуурлан ажлын 7 хоногийн дотор үнэлгээний аргачлалын дагуу эрсдэлийг нь үнэлж, дүгнэлтийг бүртгэлийн нэгжид хүргүүлнэ. Шийдвэр гаргагч нь энэхүү дүгнэлтийг харгалзана.

4.2. Зайны хяналт

Компанийн засаглал, компайнсын хэлтэс зайны хяналтыг хэрэгжүүлэх бөгөөд шаардлагатай тохиолдолд бирж болон мэргэжлийн холбоотой хамтрана. Зайны хяналтаар зохицуулалттай этгээдийн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн тайланг хагас жил тутам хянаж, эрсдэлийг шинжилж, засаглалын тогтолцоонд чанарын үнэлэлт, дүгнэлт өгч болно. Зайны хяналтын үр дүнгээр шаардлагатай тохиолдолд “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр хугацаатай үүрэг даалгавар өгөх, газар дээрх хяналт шалгалт оруулах санал боловсруулах зэрэг эрсдэлийн түвшинтэй уялдуулан арга хэмжээг авна.

Тодруулбал, Компанийн засаглал, компайнсын хэлтэс зохицуулалттай этгээдийг “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн тайланг ирүүлэх хугацаатай үүргийг нэгдсэн журмаар хүргүүлж, хэрэгжилтийг нь хангуулна. Улмаар Компанийн засаглал, компайнсын хэлтэс нь зохицуулалттай этгээдээс ирүүлсэн кодексийн хэрэгжилтийн тайланг нотлох баримтад үндэслэн хянаж, үнэлэх ба үнэлгээний дүгнэлтийг компани тус бүрээр боловсруулан тайлангийн хариуг хүргүүлнэ.

Тус хэлтэс нь компанийн засаглалын эрсдэлийн үнэлгээний оноо бүхий салбарын нэгдсэн судалгааг гаргаж, Хорооны цахим хуудсанд байршуулна.

4.3. Газар дээрх хяналт

Компанийн засаглал, компайнсын хэлтэс зохицуулалттай этгээдийн эрсдэлийн түвшингийн үр дүн болон зайны хяналт шалгалтын дүгнэлтэд үндэслэн шаардлагатай тохиолдолд газар дээрх хяналт шалгалтын төлөвлөгөөг боловсруулна.

Хяналтыг өндөр эрсдэлтэй зохицуулалттай этгээдийг давтамж өндөр, бага эрсдэлтэйг нь бага давтамжтайгаар хамруулахыг зорино.

4.4. Зөрчил, дутагдлыг арилгах

Хорооны Улсын байцаагч зайны болон газар дээрх хяналт шалгалтаар зөрчил, дутагдал илэрсэн тохиолдолд тэдгээрийг арилгуулах арга хэмжээг авна. Улсын байцаагч эрсдэлийн түвшнээс хамааруулан тайлангийн хариу, шалгалтын тайлангаар зохицуулалттай этгээдийн ТУЗ-д заавар зөвлөмж эсхүл хугацаатай албан шаардлагыг хүргүүлнэ.

Эдгээрийн хэрэгжилтийг Хороо албан бичгээр хүлээн авах ба биелэлтийг тухай бүр тооцон ажиллана.

4.5. Гүйцэтгэлийн хяналт

“Компанийн засаглалын кодекс”-ийг хэрэгжүүлэх явцад илэрсэн зохицуулалттай этгээдийн зөрчил, дутагдлыг залруулах, өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангуулах чиглэлээр

Хорооны Улсын байцаагч нэмэлт баримт бичиг, тайлбар шаардах, газар дээр очиж үзлэг хийх, ТУЗ-ийн бүрэлдэхүүнтэй уулзах зэргээр гарсан ахиц, дэвшлийг шалгах, үүрэг, даалгаврын биелэлтийг хангуулах арга хэмжээг авч болно.

Улсын байцаагч тухайн байгууллагын өмнө гаргасан зөрчил, дутагдал, тэдгээрийг залруулах чиглэлд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үүрэг даалгаврын биелэлт зэргийг компанийн эрсдэлийг үнэлэхдээ тооцно.

Зураг 1. Хяналтын үе шат



4.6. Тайлагнал, үнэлгээ

Ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг дараах байдлаар тайлагнаж, үнэлнэ:

- Компанийн засаглал, комплайнсын хэлтэс ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг жил тутам тайлагнана;
- Дотоод аудитын хэлтэс ажлын төлөвлөгөөний хэрэгжилтэд хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.

-oOo-